

Төслийн нэр: Зураач эцэг эх, хүүхэд

Хэсэг I: Төсөл санаачлагчийн мэдээлэл

Аймаг/ хот: Архангай
Сум /дүүрэг: Өлзийт
Сургууль, СЭЭБХ-ны хаяг: Өлзийт СЭЭБХ
СЭЭБХ-ны зохицуулагчийн овог, нэр: Э.Эрдэнэсүх

Хэсэг IIa. Нөхцөл байдлын шинжилгээ

Дотоод хүчин зүйлс	
<p>ДАВУУ ТАЛ</p> <ul style="list-style-type: none"> СЭЭБХ-ны үйл ажиллагаа жигдэрсэн. СЭЭБХ өрөөтэй болсон. Сум, орон нутгийн иргэд манай СЭЭБХ-ны талаар мэддэг болсон. Сумын удирдлага болон сургуулийн захиралтай сайн ойлголцож ажилладаг. СЭЭБХ ны гишүүд болон Удирдах зөвлөл хөрөнгө босгох үйл ажиллагаа явуулж эхэлж байна. Сурагчдыг зураг урлалаар хөгжүүлэх сонирхолтой, авьяастай эцэг эхчүүд байдаг. Хэлэлцүүлэгт оролцсон эцэг эхчүүдийн 70% нь хүүхдээ зургаар хөгжүүлэе гэсэн санал гаргасан. 	<p>СУЛ ТАЛ</p> <ul style="list-style-type: none"> Эцэг эхчүүдийн идэвх оролцоо сул. Сургалт, үйл ажиллагаа явуулах тоног төхөөрөмж дутагдалтай. Үйл ажиллагаа явуулахад хөрөнгө дутагдалтай. УЗ-ийн гишүүдийг чадавхжуулж компьютер дээр ажиллуулж сургах шаардлагатай. Сурагчдыг зургаар хөгжүүлэхэд багш, эцэг эхчүүдийн чадвар дутагддаг. Бага ангид зургийн мэргэжлийн багш ордоггүй. Зургийн дугуйлан хичээллэх нөхцөл боломж сул.
Гадаад хүчин зүйлс	
<p>БОЛОМЖ</p> <ul style="list-style-type: none"> Үйл ажиллагаа өргөжин тэлэх боломж бүрдсэн. Цаашид тогтвортой ажиллах нөхцөл бололцоо сайн. Хамтарч ажиллах байгууллага иргэдэд нээлтэй. 	<p>ЭРСДЭЛ</p> <ul style="list-style-type: none"> Аудит болон санхүүчийг чадавхжуулах шаардлагатай. Санхүүгийн зарцуулалт болон үйл ажиллагааг гишүүдэд байнга мэдээлж, ил тод байлгаагүйгээс гишүүдийн итгэл буурах. Үйл ажиллагаагаа иргэдэд зөв ойлгуулаагүйгээс иргэдэд буруу ойлголт төрөх. Засгийн газрын тогтворгүй байдал.

Хэсэг IIб. Төслийн зорилго, хамрах хүрээ

Зорилго	Бага ангийн сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилготой “Зургийн дугуйлан”-гийн үйл ажиллагаанд эцэг эхийг татан оролцуулах замаар сурагч, эцэг эхийн хамтдаа хөгжих боломжийг бүрдүүлнэ.
Хамрагдах	<ul style="list-style-type: none"> Сурагч: 620 Багш: 45

хүний тоо	<ul style="list-style-type: none"> • Эцэг эх: 300 • Сургуулийн удирдлагын баг
-----------	-------------------------------------------------------------------------------------------------------

Хэсэг III. Төслийг хэрэгжүүлэх зохион байгуулалт ба ажлын төлөвлөгөө

№	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн	Хугацаа	Хүрэх үр дүн
1.	Төслийн нээлтийн үйл ажиллагаа	СЭЭБХ-ны УЗ	2019.6-р сарын 1	Сумын удирдлагууд, эцэг эх, багш нарыг нээлтийн үйл ажиллагаанд урьж, СЭЭБХ-ны үйл ажиллагаа ач холбогдлыг танилцуулахаас гадна төслийн хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулна.
Сурагч, эцэг эхийн хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд				
2.	Эцэг эхчүүдтэй хамтран “Зургийн танхим” тохижуулах	СЭЭБХ, Сургуулийн удирдлага	2019.6.10-30	Зургийн дугуйлан хичээллүүлэх эцэг эх, багш хамтран дугуйлангийн танхимын тоног төхөөрөмжийг сонгож, танхимыг тохижуулснаар зургийн дугуйлан хичээллэх нөхцөл боломжоор хангагдана.
3.	Зургийн дугуйлангийн төлөвлөгөө гаргах	СЭЭБХ, Авьяаслаг эцэг эх, багш	2019.9-р сарын 10-15	Зургийн дугуйлангийн төлөвлөгөөг сурагчдын хичээлийн хуваарьтай давхцуулалгүйгээр гаргаснаар сонирхсон сурагчид дугуйланд хамрагдах нөхцөл бүрдэнэ. 2-3-р ангийн 2 бүлэг 7 хоногт үдээс өмнө 2, 2 удаа сард 30 хүүхэд, 3-4-р ангийн 2 бүлэг үдээс хойш 2, 2 удаа нийт 30 хүүхэд 1 сард 60 хүүхэд 3 сард 180 хүүхэд зургийн дугуйланд хамрагдана.
4.	Зургийн дугуйлан хичээллэх	Авьяаслаг эцэг эх, багш	2019.9.15-наас төслийн турш	Эцэг эх хүүхэдтэйгээ хамт сууж зурдаг болно. Дугуйлангийн үйл ажиллагаа нээлттэй, тогтмол болсноор эцэг эхчүүд хүүхэдтэйгээ ажиллах нөхцөл бүрдэнэ.
5.	Зургийн дугуйлангийн тайлан, сэдэвчилсэн зургийн уралдаан зохион байгуулах	СЭЭБХ	2019.11.1 2020.4.30	Зургаар дамжуулж орон нутгаа танин мэдэх, ёс заншлаас суралцах, хүмүүжлийн эерэг арга зэрэг сэдэвчилсэн бүтээлийн сан бий болно.
Эцэг эхийн бүтээлч оролцоог нэмэгдүүлэх хүрээнд				
6.	Төслийн үйл ажиллагааг таниулах	СЭЭБХ, Аймгийн Хэвлэл	2019.9.15-20	Төслийн үйл ажиллагаа бүрийг түгээх, сурталчлах “Эцэг эхийн сурвалжлах баг” гаргана. Бичих

	зорилготой сурвалжлах баг гаргах, багт зориулж сургалт зохион байгуулна.	мэдээллийн байгууллагаас дэмжлэг авна.		сонирхолтой эцэг эхийг сайн дурын үндсэн дээр энэ багт шалгаруулж авна. Сурвалжлах багийн бүтээлийг www.Sainsurquuli.mn сайт болон Сайн сургуулиас сайхан амьдрал эхэлнэ фэйсбүүк хуудсанд байршуулж, орон даяар түгээнэ. Мөн аймгийн ХМХ-ээр түгээнэ. Эцэг эхчүүдэд тараах материал байдлаар түгээнэ. Сургалтыг аймгийн хэвлэл мэдээллийн байгууллагаас арга зүйн дэмжлэг авч зохион байгуулна.
7.	Эцэг эх орон нутгийн хамтын ажиллагаа сургалт, хэлэлцүүлэг	Сумын ЗДТГ, сургуулийн удирдлага, СЭЭБХ	2019.10.18	Аймаг, сумын удирдлагуудтай хэрхэн хамтарч ажиллах тухай арга зүйн сургалтанд хамрагдаж, аймаг, сумын удирдлагуудтай хэлэлцүүлэг өрнүүлнэ. Хэлэлцүүлгийн үр дүнд хамтран ажиллах боломжуудыг ярилцаж, тохирно.
8.	Хүний эрхийн төрийн, олон улсын болон үндэсний ТББ-гуудаар болон 60-р сургуулийн зургийн дугуйлангийн туршлага судлах	СЭЭБХ	2019.9.24-27	Улаанбаатарт үйл ажиллагаа явуулдаг Хүний эрх, хүүхдийн эрх, боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн, олон улсын болон үндэсний ТББ-аар зочилж, үйл ажиллагаатай нь танилцаж, туршлага судална. Энэ бүх үйл явцыг СЭЭБХ-ны сурвалжлах баг баримтжуулна.
9.	Сурсан, мэдсэн зүйлээрээ сургуулийн эцэг эх, багш нарт мэдээлэл, сургалт зохион байгуулна.	СЭЭБХ, сургуулийн удирдлага	2019.10.8 сард	Хүмүүжлийн эерэг арга, хүүхдийн хамгаалагдах эрх зөрчигдсөн тохиолдолд хаана, хэнд хандах, эцэг эхийн оролцооны байгууллагын үйл ажиллагаа ямар байх, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэхийн ач холбогдлыг таниулсан агуулга бүхий мэдээллийг өгнө.
10.	Сурвалжлах багийн бүтээлийг эцэг эхчүүдэд түгээх	СЭЭБХ	2019.10-2020.5-р сар	Эцэг эхийн бүтээлч оролцоог нэмэгдүүлнэ. Бусад эцэг эхийг сургуулийн үйл ажиллагаанд оролцох, СЭЭБХ-ны гишүүн болох боломжийг нэмэгдүүлнэ.
11.	Төслийн хаалтын үйл ажиллагааг	Сургуулийн удирдлага, СЭЭБХ	2020.4-р сард	Аймаг, сумын удирдлагууд, сургуулийн хамт олныг урьж оролцуулна. Төслийн хүрээнд гарсан ололт амжилт, сургамжаа хуваалцана.

Хэсэг IV Зардлын задаргаа

Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ, төг	Нийт үнэ, төг	Тайлбар
Төслийн нээлтийн үйл ажиллагаа <ul style="list-style-type: none"> • Баннер • Станд • Цайны материал 	Ш Ш Ш	1 1 30	50000₮ 20000₮ 90000₮	160 000₮	Сумын удирдлагууд, эцэг эх, багш нарыг нээлтийн үйл ажиллагаанд урьж, СЭЭБХ-ны үйл ажиллагаа ач холбогдлыг танилцуулахаас гадна төслийн хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулна.
<ul style="list-style-type: none"> • Өнгөт принтер • Ламинатор А3 • Мэдээллийн самбар хийлгэх • Дуу хураагуур 	Ш Ш Ш Ш	1 1 2 1	500 000₮ 120 000₮ 50 000₮ 120 000₮	500 000₮ 120 000₮ 100 000₮ 120 000₮	Улаан баатар хотоос авна. Худалдан авсан тоног төхөөрөмжийг СЭЭБХ бэхжүүлэх үйл ажиллагаанд ашигласнаар эцэг эхчүүдийн чадварыг нэмэгдүүлнэ.
Сурвалжлах багт зориулсан сургалт	Удаа	1	8 хүн	90 000₮	Сургалтын хоол болон сургагч багшийн урамшуулал багтсан болно.
Төсөл бичих, хөрөнгө босгох сургалт	Удаа	1 удаа	9 хүн	84 000₮	Сургалтын хоол болон сургагч багшийн урамшуулал багтсан болно.
Эцэг эх, орон нутгийн хамтын ажиллагаа сургалт	Удаа	1	10 хүн	60 000₮	Сургалтын хоол болон сургагч багшийн урамшуулал багтсан болно.
Эцэг эх, орон нутгийн хамтын ажиллагаа хэлэлцүүлэг	Удаа	1	30 000₮	30 000₮	Хэлэлцүүлэгт анги тус бүрээс 30 хүн оролцуулж, хамтын ажиллагааг сайжруулахад анхаарах шаардлагатай 3 зүйлээ тодорхойлно. Хэлэлцүүлэг т хэрэглэгдэх бичиг хэргийн зардал багтана.
Туршлага судлах хөтөлбөр зардал	Удаа	1	5 хүн 4 хоног	945 000₮	УБ хотод байрлах, унаа болон бусад зардал
Туршлага судлах хөтөлбөр унааны зардал			5 хүн	250 000₮	Унааны зардал
СЭЭБХ-ны гишүүд өөрийн орон нутгийн эцэг эхчүүдэд сургалт зохион байгуулна.	удаа	2	Нэг удаа 30 хүн	100 000	Нэг удаа 30 хүн хамруулж 2 удаагийн сургалтаар СЭЭБХ-ийн гишүүн болон гишүүн бус эцэг эхчүүдийг чадавхжуулна.
Зургийн тавиур	м	20	40	800 000	Сурагчдыг анги ангиар нь бүлэг болгож 1 удаа 15

/хөлтэй/						сурагч дугуйланд хамрагдана.3-5 сард 2-5р ангийн нийт 180 сурагч дугуйланд хамрагдсан байна.
Усан будаг		м	15	9000	135 000	Зургийн дугуйлангийн сургалтад ашиглагдана.
Гуаш		ш	15	8000	120 000	
Бийр		ш	15	5000	750 00	
Аркондок		ш	15	4500	68 000	
Зургийн хүрээ,хар ватум		ш	20	2000	40 000	
Зургийн цаасА3 ватум		ш	200	500	100 000	
Цаас тогтоогч/полимит/		ш	15	4000	60 000	
Ватум цаас		ш	50	800	40 000	
Палмастер		ш	20	2000	40 000	
Бичиг хэрэг	Өнгөт принтерийн хор	ш	8	5000	40 000	Төслийн үйл ажиллагаанд ашиглагдана.
	Бичгийн цаас	ш	5	12000	60 000	
	А3 бичгийн цаас	ш	3	20000	60 000	
Харилцаа холбоо	1. Нэгж	ш	20	5000	100 000	
	2. Интернет	ш	3	25000	75 000	
Үйл ажиллагааны зардал	1. Зургийн дугуйланд хамрагдсан сурагчдын дурсамж,цом ог бүтээх	ш	50	2000	100 000	Эцэг эхчүүд хамтарч Люминатор ашиглан сурагчдын бүтээлээр цомог бүтээхэд зарцуулна.
	2.Төслийн үр дүнг олон нийтэд суртчилсан сэтгүүл гаргах	ш	45	6000	270 000	Сурвалжлах багийнхан, мэдээлэлзүй, Монгол хэлний багш нартай хамтарч төслийн үйл ажиллагаа суртчилсан сэтгүүл гаргах
	3."Номын өдөрлөг"	3 удаа	100	70000	210 000	Эцэг эх,сурагчид хамтран "Номын өдөрлөг"-ийг сард 1 удаа зохион байгуулахад зориулсан уралдаан

						тэмцээний зардал багтана.
	4.Төслийн тайлан "Өдөрлөг"	1 удаа	100,0	100,0	150 000	Төслийн хаалтын тайлан өдөрлөгт зургийн дугуйланд хамрагдсан сурагчдын бүүтээлийн үзэсгэлэн гаргах зардал,зохион байгуулагчдын зардал хамаарна.
	Худалдан авалт хийх, тээвэрлэх зардал				200 000	Худалдан авсан техник хэрэгсэл УБ-аас тээвэрлэх зардал Худалдан авалт хийхэд зорчих зардал Үйл ажиллагааны явцад ашиглах шатахууны зардал
	Банкны шимтгэл				14 000	
Бүгд						5 286 000₮









Хэсэг VI Төслийн тогтвортой байдал

Тухайн сургууль энэхүү төслийг хэрэгжүүлж

- Төслийн хүрээнд явуулж буй үйл ажиллагаанд эцэг эхчүүдийг оролцуулснаар СЭЭБХ-ны удирдлагын залгамж холбоо сайжирч,чадавхийг бэхэжнэ.
- Эцэг эхийг чадавхжуулснаар хүүхдийнхээ сурлага төлөвшилд анхаарах хандлага дээшилнэ.
- Эцэг эхчүүдийн чадвар хандлага сайжирснаар сургуулийн хүүхдэд ээлтэй,эрүүл орчин бүрдэж,сурагчдын сурлагын амжилтанд ахиц гарна.
- Эцэг эхчүүд боловсролын талаар гүнзгий мэдээлэлтэй болсноор сургууль,эцэг эхийн дунд утга учиртай холбоо харилцаа бий болно.
- СЭЭБХ өөрийн өрөө, сургалтын техник хэрэгсэлтэй болсноор үйл ажиллагаа тогтмолжино.
- Сургууль зургийн дугуйлангийн танхимтай болсноор жил бүр зурах авьяас сонирхолтой хүүхдүүдийн дугуйланд хамрагдах тоо нэмэгдэнэ.
- Дугуйланд хамрагдсан хүүхдүүдийн гадаад дотоодын тэмцээн уралдаанд оролцох боломж нээгдэж,мэргэжлийн чиг баримжаа олгох бодит үр дүнд хүрнэ.
- Зургийн дугуйланд хамрагдсанаар сурагчдын байгалийг танин мэдэх,амьдрах чадвар,гоо зүйн мэдлэг, төлөвшилд бодит ахиц гарна.
- СЭЭБХ бэхэжсэнээр хүний хөгжилд чиглэсэн тогтвортой үйл ажиллагаа явуулдаг бие даасан байгууллага болно.

Төслийн саналыг дэмжсэн гишүүдийн гарын үсэг, нэр:

СЭЭБХ-ны Зохицуулагч: Нэр: Э.Эрдэнэсүх Гарын үсэг /  /

Төслийг боловсруулсан:	Эцэг эх Т.Чулуунсүх /  /	Огноо: 2019он 01сарын 05өдөр
	Эцэг эх З.Наранцэцэг /  /	
	Эцэг эх Г.Мягмар /  /	
	Эцэг эх Г.Өлзийжаргал /  /	
	Багш: Б.Ариунаа /  /	
	Багш: Т.Өлзийсайхан /  /	
	Багш: Г.Ундармаа /  /	
Гарын үсэг:  /	